

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САМГИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /НАГ-2020/05/-НА/

Арвайхээр хот 2020 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Ламаачин
Утас: 70323253, цахим
хаяг: Lamaanchinl@audit.gov.mn

Аудитын менежер Д.Гансүх, Утас: 70323833,
цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн, Утас: 70323108,
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Ө.Ринчинмядаг, Утас: 70323108,
цахим хаяг: Renchinmyadagu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	2
Графикийн жагсаалт	2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
БҮЛЭГ-1 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмын дагуу итгэлцүүрээр хуваарилсан байна.....	6
1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан талаар орон нутагт хамааралгүй байна.	6
1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн талаар орон нутагт хамааралгүй байна.	6
1.1.2. ОНХНС-ийн эх үүсвэрээс Төсвийн тухай хуульд заасны дагуу тус аймагт 5581.1 сая төгрөг баталсан байна.....	6
1.1.3. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлд үндэслэн хуваарийн дагуу олгосон байна. 6	
1.2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль журмын дагуу хуваарилсан байна.....	7
1.2.1. Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө холбогдох журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.	7
1.2.2. ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу бүрдүүлсэн байна.	8
1.2.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилсан байна.....	8
БҮЛЭГ-2 ОНХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулсан боловч зарим ажил чанаргүй хийгдсэн байна.	10
2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримталж төлөвлөсөн байна.	10
2.1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг журмын дагуу төлөвлөсөн боловч зарим ИТХ-ын тогтоолоор эрэмбэлэгдсэн ажлыг өөрчилсөн байна.	10
2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу төлөвлөсөн байна.	11
2.2. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж зарцуулсан байна.	13
2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр сум, орон нутагт бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	13
2.2.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим ажил чанаргүй хийгдсэн байна.	14
2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэсэн байна.	18

БҮЛЭГ-3 ОНХС-д бүх шатны хяналтыг хэрэгжүүлж хэвшсэн боловч холбогдох тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлээгүй байна.....	18
3.1. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавьж хэвшсэн байна.....	18
3.1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавих ажлын хэсгийг байгуулан, хэрэгжилтийн явцад хяналт тавьж хэвшсэн байна.....	18
3.1.2. Аймаг, сумдын ОНХС-аар хийгдэж буй барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг тавьсан байна.....	19
3.2. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг заавар, журмын дагуу дээд шатны байгууллагад бүрэн тайлагнаж, хүргүүлээгүй байна.....	19
3.2.1. Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны холбогдох мэргэжилтнүүд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн, харин аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь Сангийн яаманд мэдээ тайланг бүрэн хүргүүлээгүй байна.....	19
3.2.2. Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.....	20
3.2.3. ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журам нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна. 20	
Дүгнэлт.....	21

Хүснэгтийн жагсаалт

<i>Хүснэгтийн утга</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1-ОНХСангийн санхүүжилтийн хуваарь</i>	<i>7</i>
<i>Хүснэгт 2- ОНХСангийн санхүүжилт</i>	<i>9</i>
<i>Хүснэгт 3- Аймгийн ОНХС-аас сумдад хуваарилсан байдал</i>	<i>10</i>

Графикийн жагсаалт

<i>Графикийн утга</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>График 1- ОНХСангийн төлөвлөлт</i>	<i>8</i>
<i>График 2, 3-ОНХС-ийн талаарх иргэд хэр мэдээлэлтэй байдаг, хаанаас мэдээлэл авдаг талаар</i>	<i>13</i>
<i>График 4, 5- ОНХС-аас хийгдсэн ажлуудын чанар байдлын талаар иргэдийн санал</i>	<i>14</i>
<i>График 6- ОНХС-аас олгосон санхүүжилтийг 3 жилээр харьцуулвал</i>	<i>16</i>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
ГХБХБГ газар	<i>Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар</i>
ЕБС	<i>Ерөнхий боловсролын сургууль</i>
ЖДҮХМ	<i>Жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн</i>
ЗД	<i>Засаг дарга</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
ИТХТ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид</i>
ИНХ	<i>Иргэдийн нийтийн хурал</i>
МУ	<i>Монгол Улс</i>
НА	<i>Нийцлийн аудит</i>
НАГ	<i>Нийцлийн аудитын газар</i>
ОНХНС	<i>Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан</i>
ОНХС	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
ОУТ	<i>Олон улсын төсөл</i>
СТСХ	<i>Санхүү төрийн сангийн хэлтэс</i>
ҮАГ	<i>Үндэсний аудитын газар</i>
ХОХБТХ	<i>Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс</i>
ХХК	<i>Хязгаарлагдмал хариуцлагатай компани</i>

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өвөрхангай аймгийн 2019 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад нийцлийн аудит хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг ҮАГ-т хүргүүлэн, холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад ОНХНС, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2019 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт тайлагналыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгав.

Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн болон холбогдох хэлтэс, албадын албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоол;

- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
-
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг баримтжуулсан болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын нийцлийн аудитын багийн ахлах аудитор П.Хорлоосүрэн, аудитор Ө.Ринчинмядаг нар 2020 оны 10 дугаар сарын 02-оос 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл:

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2019 оны ОНХС-ын хөрөнгөөр 208 төрлийн төсөл арга хэмжээг 6680.4 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оноос 2306.2 сая төгрөгийн санхүүжилтээр нэмэгдсэн байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 23 төсөл арга хэмжээнд 259.2 сая төгрөг, шинэ оны 185 төсөл арга хэмжээнд 6421.2 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд ОНХНС-аас 5581.0 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс гүйцэтгэлд суурилсан үнэлгээгээр урамшуулал 19 сумдад 416.3 сая төгрөг, санхүүгийн дэмжлэг 663.0 сая төгрөг, нийт 6660.3 сая төгрөг олгосон байна.

Аудитаар 5 төрлийн зөрчил арилгах 1071.2 сая төгрөгийн албан шаардлага, 5 зөвлөмж өгч 698.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг тооцон холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

БҮЛЭГ-1

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмын дагуу итгэлцүүрээр хуваарилсан байна.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан талаар орон нутагт хамааралгүй байна.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн талаар орон нутагт хамааралгүй байна.

Орон нутгийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг Сангийн яаманд тооцож байгаа тул эх үүсвэрийн төлөвлөлтийг орон нутагт үзэх боломжгүй байна.

1.1.2. ОНХНС-ийн эх үүсвэрээс Төсвийн тухай хуульд заасны дагуу тус аймагт 5581.1 сая төгрөг баталсан байна.

Сангийн яамнаас 2019 оны ОНХС-ийн эх үүсвэрт Төсвийн тухай хуулийн 59.1¹ -д зааснаар тус аймагт 5581.1 сая төгрөгийн санхүүжилт өгсөн байна.

1.1.3. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлд үндэслэн хуваарийн дагуу олгосон байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлд үндэслэн дараах байдлаар хуваарилсан байна. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэхдээ ОНХНС-аас итгэлцүүрээр хуваарилан 5581.1 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа -3 төслийн дэмжлэг 1079.3 сая төгрөг нийт 6660.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт-1 ОНХСангийн санхүүжилтийн хуваарь /сая.төг/

Сар	ОНХНС-ийн орлогын төлөвлөлт	ОНХНС-аас олгосон санхүүжилт	Зөрүү
1	155.2	155.2	0
2	179.7	137.9	41.8
3	430.8	450.1	-19.3
4	338.9	220.1	118.8
5	460.2	511.4	-51.2
6	486.3	537.5	-51.2
7	603.6	544.8	58.8

¹ Төсвийн тухай хуулийн 59.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

59.1.1.импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;

59.1.2.Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь;

59.1.3.орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

8	643.1	485.7	157.4
9	660.2	459.3	200.9
10	474.2	588.7	-114.5
11	464.3	510.9	-46.6
12	704.5	979.5	-275
Дүн	5601.0	5581.1	19.9

2019 онд ОНХНС-аас аймгийн ОНХС-д нийт 5601.0 сая төгрөг батлагдан 5581.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 19.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.


1.2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль журмын дагуу хуваарилсан байна.

1.2.1. Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө холбогдох журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох аргачлал тооцох журамд заасны дагуу аймгийн ОНХС-аас сумдад олгосон шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2 дахь “энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах”, 59.2.4 “энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй” гэсэн заалтыг үндэслэн Тогтвортой амьжиргаа-3 төслийн урамшуулал, дэмжлэг, орон нутгийн суурь зардлыг хасаж тооцон сумдад нийт эх үүсвэрийн 30 хувь буюу 1505.7 сая төгрөг, аймагт 70 хувь буюу 3513.2 сая төгрөг төлөвлөсөн байна.

График-1

ОНХСангийн төлөвлөлт /сая.төг/



1.2.2. ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу бүрдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 09/10 тоот тогтоолоор ОНХС-ийн хөрөнгийг аймагт 3513.3 сая төгрөг, суманд 2684.2 сая төгрөг, суурь зарлага 482.8 сая төгрөгөөр нийт 6680.4 сая төгрөгөөр баталсан байна.

ОНХС-ийн 2019 оны төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-2		ОНХСангийн санхүүжилт /сая.төг/				
№	Сумдын нэр	ОНХС	ОУТ Хөтөлбөр	ОУБТХ-өөс олгосон урамшуулал	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	Нийт эх үүсвэрийн дүн
1	Баян-Өндөр	66.5	29.3	20.7	18.6	135.1
2	Бүрд	54.0	23.8	16.7	2.4	96.8
3	Бат-Өлзий	103.0	45.4	31.7	0.0	180.1
4	Баруунбаян-Улаан	67.5	29.7	20.9	1.7	119.7
5	Баянгол	61.7	27.2	19.0	1.8	109.7
6	Гучин-Ус	57.0	25.1	17.7	0.0	99.8
7	Есөнзүйл	47.7	21.0	14.7	0.5	83.9
8	Өлзийт	36.4	16.0	11.3	2.0	65.7
9	Зүүнбаян-Улаан	50.1	22.1	15.5	3.5	91.2
10	Богд	157.7	69.4	0.0	20.9	248.1
11	Нарийнтээл	63.2	27.8	19.3	3.1	113.5
12	Сант	55.6	24.5	17.1	0.0	97.2
13	Тарагт	47.9	21.1	14.8	16.4	100.1
14	Төгрөг	66.8	29.4	20.7	0.0	116.9
15	Уянга	101.1	44.5	31.5	27.5	204.6
16	Хайрхандулаан	60.7	26.7	18.8	0.9	107.1
17	Хужирт	75.9	33.4	23.4	0.0	132.7
18	Хархорин	167.7	73.8	52.0	0.0	293.6
19	Арвайхээр	165.2	72.7	50.5	0.0	288.4
	Сумын нийт санхүүжилт	1505.7	663.0	416.3	99.2	2684.2
20	Аймаг	3513.3	0.0	0.0	0.0	3513.3
	Суурь зарлага	0.0	0.0	0.0	0.0	482.9
	Нийт аймгийн дүн	5019.0	663.0	416.3	99.2	6680.4

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэхдээ ОНХНС-аас итгэлцүүрээр хуваарилах дүн 5019.0 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 1079.3 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50.0 хувь буюу 99.2 сая төгрөг, суурь зарлага 482.9 сая төгрөг нийт 6680.4 сая төгрөгөөр бүрдүүлсэн байна.

1.2.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилсан байна.

Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3², Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны 230 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлалд³ заасан хувийн жинд харгалзуулан аймгийн ОНХС-аас журамд заасан итгэлцүүрээр хуваарилсан байна. Аймгийн ОНХС-ийн хөрөнгийг сумдад итгэлцүүрээр хуваарилсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-3 Аймгийн ОНХС-аас сумдад хуваарилсан байдал (сая.төг)

№	Сумын нэр	Алслалтаас хамаарах хуваарилалт 30%	Хүн амын тооноос хамаарах хуваарилалт 40%	Нутаг дэвсгэрээс хамаарах хуваарилалт 30%	Итгэлцүүрээр хуваарилах суурь дүн	АМХБАТЗ-ийн төлбөрийн 50%	Тогтвортой амьжиргаа төсөл	Сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлэгийн дүн
1	Арвайхээр	0.0	163.9	1.2	165.2	0.0	123.2	288.4
2	Бат-Өлзий	46.5	39.0	17.4	103.0	0.0	77.1	180.1
3	Баянгол	15.8	20.5	25.4	61.7	1.8	46.2	109.7
4	Баян-Өндөр	23.3	19.9	23.3	66.5	18.6	50.0	135.1
5	Баруунбаян-Улаан	24.6	14.6	28.3	67.5	1.7	50.6	119.7
6	Богд	55.5	29.3	72.9	157.7	20.9	69.4	248.1
7	Бүрд	20.1	15.4	18.5	54.0	2.4	40.4	96.8
8	Гучин-Ус	11.4	11.4	34.1	57.0	0.0	42.8	99.8
9	Есөнзүйл	15.6	16.2	15.9	47.7	0.5	35.7	83.9
10	Зүүнбаян-Улаан	9.6	21.2	19.4	50.1	3.5	37.6	91.2
11	Нарийнтээл	24.8	19.1	19.4	63.2	3.1	47.2	113.5
12	Өлзийт	10.8	12.7	12.9	36.4	2.0	27.3	65.7
13	Сант	18.2	19.0	18.4	55.6	0.0	41.6	97.2
14	Тарагт	5.9	17.6	24.4	47.9	16.4	35.8	100.1
15	Төгрөг	13.1	14.4	39.3	66.8	0.0	50.1	116.9
16	Уянга	29.0	49.5	22.5	101.1	27.5	76.0	204.6
17	Хайрхандул аан	12.7	18.3	29.7	60.7	0.9	45.5	107.1
18	Хархорин	86.5	65.2	16.1	167.7	0.0	125.9	293.6
19	Хужирт	28.4	35.1	12.3	75.9	0.0	56.8	132.7
	Нийт дүн	451.7	602.3	451.7	1505.7	99.2	1079.3	2684.2

² 59.3.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

- 59.3.1.орон нутгийн хөгжлийн индекс;
- 59.3.2.хүн амын тоо;
- 59.3.3.хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;
- 59.3.4.орон нутгийн татварын идэвх санаачилга.

³ Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17 ны 230 дугаар тогтоол

- 3.2.1 орон нутгийн хөгжлийн индекс- харгалзах хувийн жин 25 хувь;
- 3.2.2 хүн амын тоо-харгалзах хувийн жин 25 хувь;
- 3.2.3 хүн амын нягтрал, алслалтын хэмжээ-харгалзах хувийн жин 25 хувь;
- 3.2.4 орон нутгийн татварын идэвх санаачилга-харгалзах хувийн жин 25 хувь;

БҮЛЭГ-2

ОНХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулсан боловч зарим ажил чанаргүй хийгдсэн байна.

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримталж төлөвлөсөн байна.

2.1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг журмын дагуу төлөвлөсөн боловч зарим ИТХ-ын тогтоолоор эрэмбэлэгдсэн ажлыг өөрчилсөн байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдээс санал авах маягтаар болон олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж, багуудын ИНХ-аар хэлэлцүүлэн саналыг тэргүүлэх ач холбогдол бүхий орон нутагт тулгамдсан асуудлын дарааллаар эрэмбэлэн сумын ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

Харин аймаг, сумын хурлын тогтоолоор батлагдсан дараах эрэмбэлэгдсэн ажлуудыг өөрчилж шинээр эрэмбэлэгдээгүй ажил хийсэн байна. Үүнд:

- ✚ Уянга сумын явган хүний зам тавих 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг ИТХ-ын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03 тоот тогтоолоор иргэдийн санал эрэмбэлтэл ороогүй авто замын бордуурын ажил болгож өөрчлөн, хийж гүйцэтгэсэн байна.
- ✚ Аймгийн төвд нийтийн бие засах газар барих 138.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/08 тоот тогтоолоор иргэдийн санал эрэмбэлтэл ороогүй Усан спорт сургалтын төвийн гадна дулаан бохир, гадна цахилгааны ажил хийсэн байна.
- ✚ Аймгийн төвд унадаг дугуйн зам барих 165.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг аймгийн ИТХ-ын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03 тоот тогтоолоор иргэдийн санал эрэмбэлтэл ороогүй Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга барьсан байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн нийт 208 төсөл арга хэмжээний 23 нь урд оноос шилжиж ирсэн, 185 төсөл арга хэмжээг шинээр санхүүжүүлсэн байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт төсөл хөтөлбөрийг хуулийн заалт тус бүрээр задалж үзэхэд:

- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.3. сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хогийн цэг цэгцлэх чиглэлээр 39 ажил 729.9 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.4. мал, амьтны халдварт, шимэгчтэй өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 15 ажил 76.7 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.5. сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх чиглэлээр 6 ажил 66.7 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.6. сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах чиглэлээр 8 ажил, 109.6 сая төгрөгөөр

- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.7. сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах чиглэлээр 6 ажил 59.9 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.8. сумын тохижилт, мод, ургамал цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах арчлах чиглэлээр 23 ажил 577.3 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.9. усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 7 ажил 84.7 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.10. орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх чиглэлээр 44 ажил 720.5 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.4.11. хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр 29 ажил 378.4 сая төгрөгөөр, нийт 19 суманд 177 төсөл хөтөлбөрийг 2803.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн 19 сумын 20492 иргэнээс 37489 санал авч нийт 637 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал ирж 176 төсөл хөтөлбөр нь батлагдаж, 461 төсөл хөтөлбөр дэмжигдээгүй байна.

2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу төлөвлөсөн байна.

Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн иргэдийн санал авч, нэгдсэн жагсаалтыг гарган, багийн иргэдийн нийтийн хурлын тогтоолоор батлан эрэмбэлсэн саналыг тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж төсвийн төсөлд тусган ИТХ-аараа батлан хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумдын 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сангийн хөрөнгөөр хийх ажлын санал хураалтыг зохион байгуулах ажлын хэсгийг аймаг, сумдад байгуулан ажилласан байна.

Аймаг, сумдын Засаг дарга нар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төслийн урьдчилсан саналын жагсаалтыг Төсвийн тухай хууль, журмын дагуу боловсруулан иргэдээс багуудын ИНХ-аар саналыг авч хэлэлцүүлсэн байна.

Аймагт хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийг Төсвийн тухай хуулийн заалтаар ангилан харуулбал:

- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.3. орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх чиглэлээр 5 ажил 1681.4 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.10. усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, орон сууц, нийтийн аж ахуй, үерийн хамгаалалтыг зохион байгуулах чиглэлээр 1 ажил 138.3 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.11. нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 1 ажил 320.0 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.14. аймгийн доторх болон сум хоорондын авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох чиглэлээр 1 ажил 300.0 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.15. аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хогийн цэг цэгцлэх чиглэлээр 5 ажил 765.0 сая төгрөгөөр

- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.16. аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр 1 ажил 40.0 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.18. соёлын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 1 ажил 30.0 сая төгрөгөөр
- ✚ Төсвийн тухай хуулийн 58.2.20. хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр 1 ажил 128.0 сая төгрөгөөр нийт 16 ажил 3420.7 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна.

Аймгийн төвийн 674 иргэнээс 4484 санал авч нийт 56 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал ирж 16 төсөл хөтөлбөр нь батлагдаж, 40 төсөл хөтөлбөрийн санал дэмжигдээгүй байна.

Тус аудиттай холбогдуулан аймаг, сумдын нийт 224 иргэнээс санал асуулга авсныг дараах графикаар харуулав:

График-2,3 ОНХС-ийн талаарх иргэд хэр мэдээлэлтэй байдаг, хаанаас мэдээлэл авдаг талаар



Таны баг, хорооны Засаг дарга 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?

- Тийм-106
- Үгүй-40
- Сайн мэдэхгүй-78

Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?


- Тийм-82
- Үгүй-142

Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?

- Тийм- 93
- Үгүй- 48
- Сайн мэдэхгүй-83

График-4, 5

ОНХС-аас хийгдсэн ажлуудын чанар байдлын талаар иргэдийн санал



Иргэдийн санал асуулгаар доорх нийтлэг ажил, арга хэмжээний саналууд гарсан байна. Үүнд:

- ✚ Таны оршин суугаа нутаг дэвсгэрт ОНХС-аар 2019 оноос өмнө хэрэгжсэн бодит үр дүнтэй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс нэрлэнэ үү.
Явган хүний зам, гэрэлтүүлэг, засмал зам, цэцэрлэг, сургуулийн засвар, угаалгын ванн
- ✚ Таны оршин суугаа нутаг дэвсгэрт 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажил бодит үр дүнтэй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс нэрлэнэ үү.
Явган хүний зам, спорт заал, дотуур байр засвар хийсэн, мал угаалгын ванн, дулааны шугам
- ✚ Танд энэ сангийн үйл ажиллагаатай холбоотой санал байна уу?
Санхүүжилт нэмэх хэрэгтэй, сангийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах

2.2. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж зарцуулсан байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр сум, орон нутагт бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймаг, сумдын үнэлгээний хорооны гишүүд бүгд худалдан авах ажиллагааны чиглэлийн сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

Тендерийн урилга, мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны “e-procurement.mof.gov.mn”, “procurement.ov.gov.mn”, “uvurkhangaai.mn” сайтууд болон үндэсний хэмжээний өдөр тутмын сонин болох Зууны мэдээ сонин, мэдээллийн самбараар мэдээллээ байршуулсан байна.

Тендерийн баримтаас үзэхэд аймаг, сумууд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, Тендерийн нээлтийн тэмдэглэл, үнийн саналууд, тендерийг хянан үзэх, маягуудыг хөтөлж хэвшсэн байна.

Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна. Тухайлбал:

- ✚ Аймгийн төвд шинээр баригдах Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын угсралтын ажил “БИАНКОНЭРО КОНСТРАШН” ХХК 983.5 сая төгрөгөөр шалгарсан.
- ✚ Өвөрхангай аймгийн Төгрөг сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил “Гуа-Орд” ХХК 179.1 сая төгрөгөөр шалгарсан.
- ✚ Арвайхээр суманд Усан спортын цогцолбор барилгын барилга угсралт, халаалт салхивч, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг гүйцэтгэхээр “ӨВМТХ” ХХК 3956.4 сая төгрөгөөр шалгарсан.
- ✚ Аймгийн төвийн камерын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил “Баттод” ХХК 394.9 сая төгрөгөөр шалгарсан.
- ✚ Баруунбаян-Улаан сумын явган хүний зам тавих, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажилд “ЭС ЖИ ЭМ” ХХК 43.5 сая төгрөгөөр тус тус шалгарсан байна.

Харин Хужирт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 75.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дугуйт ачигч ковш машин нийлүүлэх тендертэй холбоотой “Сонор гуа сольюшн” ХХК Сангийн яаманд гомдол гаргаж, тухайн компани шаардлага хангаагүй болох нь үнэн гэдгийг баталсан шийдвэр гарсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газарт Баян-Өндөр сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хийх ажлын жагсаалтад эрэмбэлэгдсэн ЕБС, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хатуу зөөлөн эдлэл авах 15.0 сая төгрөгийн тендер шалгаруулах үйл ажиллагаанд аудит хийж өгнө үү гэсэн хүсэлт ирсний дагуу тендерийн баримтыг шалган үзэхэд 2 удаа харьцуулалтын аргаар цахимаар тендер зарласан боловч “Пүүлэг” ХХК-аас өөр үнийн санал ирээгүй тул дотуур байрны зөөлөн эдлэлийг 11.8 сая төгрөгөөр нийлүүлэхээр Засаг даргын захирамж гарч гэрээ байгуулан гэрээний дагуу бараа нийлүүлэгдсэн байна. Бараа хүлээн авахад зөөлөн эдлэлийн хэмжээ техникийн тодорхойлолтод зааснаас бага зэрэг өөрчлөгдөж ирсэн ч тендер шалгаруулалтад ямар нэгэн асуудал гараагүй байна.


2.2.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим ажил чанаргүй хийгдсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас дараах ажлууд үр дүнгээ өгсөн байна. Үүнд:

- ✚ Сум болгон камержуулалд хийгдсэнээр иргэдийн амгалан тайван байдал үүсэж, хулгай багассан байна.
- ✚ Бүх суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулагдаж хүүхэд багачуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, таатай орчин бүрдүүлж өгсөн байна.
- ✚ Аймгийн төв дээр усан спортын төв, кино театр байгуулагдсанаар иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, цаашид соёлын талаар авч хэрэгжүүлж байгаа томоохон арга хэмжээ болж, үр дүнгээ өгсөн ажлууд хийгдсэн байна.
- ✚ Хужирт сумын “ЕБС-ийн анги танхимд уян камер, камер, телевизтэй болох” гэсэн 18.3 сая төгрөгийн ажил хийгдсэн. Тус ажил нь үр дүн, ач холбогдол сайтай, багш тараах материалыг олон хувилж, олшруулах шаардлагагүй мөн гар бичмэл, зураг зэргийг шууд сурагчдад нэгэн зэрэг харуулах, сурах бичгийн хүрэлцээгүй үед багш номыг шууд сурагчдад телевизээр дамжуулан харуулах боломж бүрдсэн байна.
- ✚ Хархорин сумын Эрдэнэ-Зуу хийдийн урд талын нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах ажил хийгдсэн бөгөөд аялал жуулчлалын бүс нутгийн хувьд ач

холбогдол бүхий ажил нь 190 метр урттай, 3 метр өргөнтэй явган хүний зам, авто замын хашлага, ногоон зурвас талбайд хар шороо дэвсэж зүлэг тарих талбайн хөрс бэлтгэх ажлууд хийгдсэн байна.

Зураг 1-Усан спорт сургалтын төв



Зураг 2- Кино театр



Зураг 3- Хужирт сумын ЕБС-ийн анги танхимд уян камер, камер, телевиз



Зурагтаар багш материал харуулж байгаа байдал




Зурагтад холбогддог хөдөлгөөнт камер

Зураг 4- Эрдэнэ-Зуу хийдийн урд талын нийтийн эзэмшлийн талбайн тохижилт



График-6 ОНХС-аас олгосон санхүүжилтийг 3 жилээр харьцуулбал



Дээрх графикаас харахад ОНХС-ийн хөрөнгө оруулалт жил бүр 2 дахин нэмэгдэж үр дүнгээ өгсөн байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дараах ажлууд чанаргүй хийгдсэн, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл үүссэн байна. Үүнд:

1. Арвайхээр сумын Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил 25.0 сая төгрөгөөр хийгдсэн боловч ургалтын хувь хангалтгүй байна. Нийт хайлаас 5000 ширхэг, улиас 1200 ширхэг мод бут бөгөөд ургалт нь 60 хувиас бага тохиолдолд нөхөн тарилтын гүйцэтгэгч тал болох “Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ хариуцна гэж гэрээнд тусгасан байна.

2. Арвайхээр сумын Үерийн далан шуудуу татах, газрын хотгор гүдгэрийг тэгшлэх ажлыг 4.9 сая төгрөгөөр хийхээр иргэн Д.Буманнасттай гэрээ байгуулж хийсэн нь үр дүн муутай ажил болсон байна.
3. Арвайхээр сумын нийтийн орон сууцны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг иргэн Б.Цэрэнпүрэвтэй 2019 оны 01 дүгээр сарын 31-нд 9.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан орон сууцуудын орцны гэрэлтүүлэгт 600 ширхэг гэрэл тавьж 8.9 сая төгрөг зарцуулсан байна. Тухайн орон сууцууд нь Онги-Өргөө, Найрамдал СӨХ-ийн мэдэлд байгаа хувийн орон сууцууд байна. Тухайн орон сууцны СӨХ нь оршин суугчдаас сар бүр 10.0 мянган төгрөг хурааж авдаг боловч тэр нь зөвхөн байрны цэвэрлэгчийн цалинд явдаг гэсэн тайлбар өгч байна.
4. Арвайхээр сумын 3-р багийн төвийн байрыг засварлах ажилд 9.8 сая төгрөг төлөвлөж 5.9 сая төгрөг зарцуулж, засварын ажил хийгдсэн боловч уг барилгыг өөр барилга барихаар нурааж үр дүнгүй хөрөнгө оруулалт болсон байна.
5. Бат-Өлзий суманд гүний худаг шинээр барих 16.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил техникийн тодорхойлолтын дагуу хийгдээгүй, хаяавч дутуу, цонхны хаалт хийгдээгүй байна.
6. Хархорин сумын Хот тохижилт, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, арчлалтын ажлаар техникийн тодорхойлолтод хашааны багана бүрд бетон цутган суулгах гэж заасан боловч ажилтай танилцахад бетон цутгаагүй шууд газарт суулгасан байв.
7. Уянга сумын төвд 2020 оны 05 дугаар сард ашиглалтад орсон 86.8 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн ажил харуул хамгаалалт муутайгаас гаднын нөлөөтэй /бусдын санаатайгаар хийсэн/ эвдрэл их гарсан байна.
8. Уянга сумын төвийн камержуулах ажлаар хөдөлгөөнт 3, чиглэлийн 3-н камер тавигдсан бөгөөд тус камеруудаас 2 камер гэмтэл үүссэн, ашиглалтгүй, ашиглалтын байдал хангалтгүй байна. Камерын ашиглалтын явцад гэмтэл үүссэн талаар захиалагч тал гэмтлийн учир шалтгааныг тодруулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Тус аймагт 2019 онд ашиглалтад орсон ихэнх төсөл, арга хэмжээнүүд бүрэн хүчин чадлаар ашиглагдаж байна. Харин ОНХС-аар хэрэгжсэн дараах төсөл, арга хэмжээнүүд ашиглалтгүй байна. Үүнд:

1. Гучин-Ус сумын Дулаан болон цэвэр усны шугам тавих ажил 44.3 сая төгрөгөөр хийгдсэн боловч дулааны эх үүсвэргүйн улмаас ашиглаагүй байна.
2. Аймгийн төвийн Гудамж талбайн камержуулах өргөтгөлийн ажил 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Баттод ХХК-тай 394.9 сая төгрөгөөр хийлгэхээр гэрээ байгуулан ажилласан боловч одоог хүртэл ашиглалтад оруулаагүй ажил нь дуусаагүй байна. /Гэрээнд 2019 оны 08 дугаар сарын 01-ний дотор хүлээж авахаар, ашиглалтад оруулах үүргээ биелүүлээгүй бол 0,01 хувьтай тэнцэх торгуулийг хоцорсон хоног тутамд төлөхөөр тусгасан байна/
3. Арвайхээр сумын малчны хорооллыг цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг хийхээр “Дүүрэн цацрах” ХХК шалгарч 39.2 сая төгрөгөөр хийсэн байна. Комисс 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авсан боловч аймгийн төвөөс зайдуу орших малчны хороолол нь шинээр бий болж байгаа учир одоогоор айл өрх байхгүй тул цахилгааны шугамыг ашиглаад эхлэнгүүт цахилгааны үргүй зардал гарна гэсэн шалтгаанаар ашиглаагүй байна.

Техникийн тодорхойлолт бүрэн судалгаагүй, зураг төсвийн ажлууд тааруу хийгдсэнээс дараах ажлууд чанаргүй, стандартад нийцэхгүй байна. Үүнд:

1. Төгрөг сумын Хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн урлаг заалны цонх, дээвэр нь спорт залны стандартаар баригдсан, ангийн агааржуулалт хийгдээгүй байна.
2. Арвайхээр сумын 150 хүүхдийн Цэцэрлэгийн агааржуулалт буруу хийгдсэнээс мөөгөнцөр үүссэн, үнэр ихтэй байна.
3. Аймгийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт хийх ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 45 ширхэг сандал нь техникийн тодорхойлолтод нийцэж байгаа боловч суурилуулалтын явцад материалын хэврэг байдлаас үүдэлтэй чанарын асуудал үүссэн тул 17 сандлыг байршуулаагүй байна.
4. Аймгийн Зам цэвэрлэгээний машиныг “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ 85.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан нийлүүлсэн. Техникийн тодорхойлолтод замын шороо болон цас цэвэрлэгээний зориулалттай гэж заасан боловч зөвхөн замын тоос цэвэрлэх зориулалттай машин нийлүүлсэн байна.
5. Уянга сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын дээвэр хулдаасан материалаар хийгдсэн бөгөөд байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр урагдах, эдэлгээ муутай байх тул цаашид байгалийн хүчин зүйлд тэсвэртэй байдал дээр илүү сайн анхаарч техникийн тодорхойлолтод тусгах шаардлагатай байна.
6. Хужирт сумын дугуйт Ковш нийлүүлэх ажилд “Мон Гео Саплай” ХХК нь анх оролцоходоо 72.0 сая төгрөгийн үнийн саналтай оролцож тодорхой тендерийн шалгаруулалт хангаагүй учир хасагдсан. 2 удаа тендер шалгаруулалт явагдсаны дараа тус ажлыг Мон Гео Саплай ХХК-тай шууд гэрээ байгуулсан 74.9 сая төгрөгөөр буюу анх өгсөн үнийн саналаас 2.9 сая төгрөгийн илүү үнээр нийлүүлсэн байна. Мон Гео Саплай ХХК-ний нийлүүлсэн ковш нь хятадын улсын үйлдвэрийн ковш байсан боловч газар дээр очиж үзэхэд техникийн тодорхойлолтоос зөрүүтэй 2019 оноос хойш үйлдвэрлэгдсэн байх гэж заасан боловч тухайн ковш нь 2017 онд үйлдвэрлэгдсэн байна.

2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

БҮЛЭГ-3

ОНХС-д бүх шатны хяналтыг хэрэгжүүлж хэвшсэн боловч холбогдох тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад бүрэн хүргүүлээгүй байна.

3.1. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавьж хэвшсэн байна.

3.1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавих ажлын хэсгийг байгуулан, хэрэгжилтийн явцад хяналт тавьж хэвшсэн байна.

Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 77 тоот тогтоолоор ажлын хэсэг байгуулан аймгийн 2019 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдсан аймгийн ажлуудын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг шалгаж үзэн ажлын чанар, үр дүнг үнэлж, дүгнэлт гаргахдаа дараах шалгуурыг авч үзсэн байна. Үүнд:

- ТБОНӨХБАУХА тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилт / 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, 49.3/
- Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт болон тендерийн баримт бичигтэй танилцаж, ажлын хэсэг ажиллах шалгуур үзүүлэлтийг боловсруулах.
- Тухайн хөрөнгө оруулалтын ажлын захиалагч болон ашиглагчийн хяналтын тайлантай танилцах
- Ажлын гүйцэтгэлийн явцтай танилцах ажлуудыг үзэж үүрэг даалгавар өгсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Уянга, Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Хайрхандулаан, Нарийнтээл, Баруунбаян-Улаан, Богд сумдын ИТХ болон ЗДТГ-аас хяналт шалгалт хийх комисс томилж, удирдамж боловсруулан явцын болон гүйцэтгэлийн шатны хяналтуудыг хийж ажлын хэсгийн дүгнэлт гарган хэлэлцэж, үүрэг даалгавар өгч хэвшжээ.

Харин Төгрөг, Гучин-Ус, Уянга, Арвайхээр сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын явцад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.1.2. Аймаг, сумдын ОНХС-аар хийгдэж буй барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг тавьсан байна.

Аймгийн ЗД-ын дэргэдэх ГХБХБГ-аас ОНХС-аар хийгдэж буй дараах барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг тавьсан байна. Үүнд:

- ✚ Усан спортын төвийн барилгын ажлын явцад хяналт тавьж үүрэг даалгавар өгсөн байна.
- ✚ Нийтийн орон сууцны 2 барилгын засварын ажилд явцын хяналт тавьсан.
- ✚ Төгрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилгын ажилд хяналт тавьсан.
- ✚ Арвайхээр сумын 13 дугаар багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих ажлын явцад хяналт тавьсан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын алба 2019 оны ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийгээгүй тухай 2020 оны 10 дугаар сарын 20-ны 84 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна.

3.2. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг заавар, журмын дагуу дээд шатны байгууллагад бүрэн тайлагнаж, хүргүүлээгүй байна.

3.2.1. Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны холбогдох мэргэжилтнүүд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн, харин аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь Сангийн яаманд мэдээ тайланг бүрэн хүргүүлээгүй байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас дараах тайлан мэдээг гаргаж Сангийн Яаманд хүргүүлсэн байна. Үүнд:

- ✚ Сангийн сайдад 2019 оны 01 дүгээр сарын 07-нд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.7 дах заалтын дагуу 2018 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг жилийн эцсийн байдлаар нэгтгэн

- Сангийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу боловсруулан хүргүүлсэн байна.
- ✚ Сангийн сайдад 2019 оны 08 дүгээр сарын 1-нд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дүгээр зүйлийн дагуу Сангийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.3-д заасны дагуу 2020 онд зохион байгуулагдах төсөл арга хэмжээний төслийг нэгтгэн хүргүүлсэн байна.
 - ✚ Сангийн сайдад 2019 оны 07 дүгээр сарын 06-нд 2019 оны хагас жилийн байдлаарх худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу боловсруулан хүргүүлсэн байна.
 - ✚ Сангийн сайдад 2020 оны 01 дүгээр сарын 13-нд 2019 оны жилийн эцсийн байдлаарх худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу нэгтгэн хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.9-д зааснаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлнэ гэсний дагуу сумууд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг аймагт ирүүлсэн боловч аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь Сангийн яаманд мэдээ тайлан хүргүүлээгүй байна.

3.2.2. Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх аудитаар 2019 оны 08 дугаар сарын 10-ны дотор хэрэгжүүлэхээр 8 төрлийн 181.7 сая төгрөгийн албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлж бүрэн хэрэгжсэн байна.

3.2.3. ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журам нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны 228 дугаар тушаалаар ОНХС-ийн үйл ажиллагааны журам батлагдаж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журам нь бусад хууль тогтоомжтой уялдаж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг аймаг, сумдын санхүүгийн алба бүрэн хэрэгжүүлж төсөл арга хэмжээ тус бүрээр мэдээллийг байршуулж хэвшсэн байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгийг Орон нутгийн хөгжилд чиглэсэн, бодит үр дүнгээ өгөх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг санхүүжүүлэх чиглэл баримтлахаар ОНХС-ийн журмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дээрх журмаар хөрөнгийн зарцуулалтыг өргөн хүрээнд тавьж өгснөөр ихэвчлэн урсгал зардалд зарцуулагдаж, орон нутгийн хөгжилд дэмжлэг болох зорилт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Тухайлбал: Хөдөөгийн багийн иргэдийн нийтийн хурлаар янз бүрийн жижиг ажлын саналууд гарч ирж эрэмбэлэгдсэнээс суманд үр ашиг муутай жижиг ажлууд нэлээд хийгдсэн байна. /Хуралд оролцсон иргэд өөрсдийн ойр тойрны худаг засварын ажил, малын дэрс хашаалах ажил, булаг шанд сэргээх гэх мэт/

Дүгнэлт

БҮЛЭГ-1 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмын дагуу итгэлцүүрээр хуваарилсан байна.

1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан талаар орон нутагт хамааралгүй байна

1.1.1. ОНХС-ийн эх үүсвэрийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн талаар орон нутагт хамааралгүй байна.

1.1.2. ОНХС-ийн эх үүсвэрээс Төсвийн тухай хуульд заасны дагуу тус аймагт 5581.1 сая төгрөг баталсан байна.

1.1.3. ОНХС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлд үндэслэн хуваарийн дагуу олгосон байна.

1.2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль журмын дагуу хуваарилсан байна.

1.2.1. Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө холбогдох журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.

1.2.2. ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу бүрдүүлсэн байна.

1.2.3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилсан байна.

БҮЛЭГ-2 ОНХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулсан боловч зарим ажил чанаргүй хийгдсэн байна.

2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримталж төлөвлөсөн байна.

2.1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг журмын дагуу төлөвлөсөн боловч зарим ИТХ-ын тогтоолоор эрэмбэлэгдсэн ажлыг өөрчилсөн байна.

2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу төлөвлөсөн байна.

2.2. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталж зарцуулсан байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр сум, орон нутагт бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим ажил чанаргүй хийгдсэн байна.

2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэсэн байна.

БҮЛЭГ-3 ОНХС-д бүх шатны хяналтыг хэрэгжүүлж хэвшсэн боловч холбогдох тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад бүрэн хүргүүлээгүй байна.

3.1. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавьж хэвшсэн байна.

3.1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавих ажлын хэсгийг байгуулан, хэрэгжилтийн явцад хяналт тавьж хэвшсэн байна.

3.1.2. Аймаг, сумдын ОНХС-аар хийгдэж буй барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг тавьсан байна.

3.2. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг заавар, журмын дагуу дээд шатны байгууллагад тайлагнаж, хүргүүлээгүй байна.

3.2.1. Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны холбогдох мэргэжилтнүүд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн, харин аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь Сангийн яаманд мэдээ тайланг хүргүүлээгүй байна.

3.2.2. Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.2.3. ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журам нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Зөвлөмж:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ, ЗДТГ-ЫН ХОХБТХ-ИЙН ДАРГА Г.БАЯСГАЛАН

НАРТ:

1. Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны 228 дугаар тушаалын 9.9-д зааснаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх.
2. Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг өөрчилж хууль журамд нийцээгүй ажил, үйлчилгээ төлөвлөн хэрэгжүүлэхгүй байх.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг ажлын гэрээнд заасан хугацаанд, чанартай гүйцэтгүүлэхэд анхаарч ажиллах.

АЙМГИЙН ЗД-ЫН ДЭРГЭДЭХ ГХБХБГ-ЫН ДАРГА Ч.ГҮНСЭНХОРОЛ ТАНАА

Барилга байгууламжийн зураг төсвийг хянахдаа ашиглах зориулалтын дагуу стандартад нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллах.

ЗӨВЛӨМЖ: БАТ-ӨЛЗИЙ, УЯНГА, ХУЖИРТ, ХАРХОРИН, АРВАЙХЭЭР СУМДЫН ЗАСАГ

ДАРГА НАРТ

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажлын зураг, төсөв болон техникийн тодорхойлолтыг нарийвчлан тооцоолж, чанар байдлын талаар тодорхой тусгаж өгөх.

Холбогдох байгууллагын санал



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас: 7032 2073

2020. 11. 10 № 28/575
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн Засаг даргын А/697 дугаар захирамжаар хяналт тавих ажлын хэсэг байгуулагдан “Баттод” ХХК-ийн гүйцэтгэж байгаа камержуулалтын өргөтгөл шинэчлэлийн ажилд 10 гаран удаа үе шатны хяналт хийж, 6 удаа үүрэг даалгавар өгч, ажлын дэвтэрт бичиж хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан.

Аймгийн нийтийн эзэмшлийн талбайд суурилуулсан 45 сандлаас хоёр сандалд үүссэн эвдрэл нь иргэдийн ашиглалтын буруугаас үүдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 85.0 сая төгрөгийн хөрөнгөөр зам болон цас цэвэрлэгээний хосолмол ажиллагаатай автомашин авах гэсэн боловч төсөвт өртөг нь хүрэлцээгүй учраас зөвхөн зам цэвэрлэгээний автомашин авсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын болон мөнгөн урсгалын тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 2/67, гүйцэтгэл, зарцуулалтын тайланг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2в/83 тоот албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн болно.

Хавсралт 5/ хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.БАЯСТАЛАН 300941


ГНДА0003

D:\My Doc. A5 alban bichig /ZDTG/

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Аймгийн ЗДТГ-с ирүүлсэн хариу албан тоотод дараах тайлбаруудыг өгч байна. Үүнд:

- Аймгийн ХОХБТХ-ийн хэлтсээс аудитын явцад Баттод ХХК-ийн гүйцэтгэж буй аймгийн төвийн Гудамж талбайн камержуулах өргөтгөлийн ажлын явцад хяналт тавьсан баримт, материалуудыг ирүүлээгүй. Тайлангийн төсөлд хариу ирүүлэхдээ 2 удаагийн хурлын протокол, зургуудын хамт ирүүлсэн байна. Иймд тус саналыг хүлээн авч тайлангаас хасав.
- Аймгийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт хийх ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 45 ширхэг сандал нь техникийн тодорхойлолтод нийцэж байгаа боловч суурилуулалтын явцад материалын хэврэг байдлаас үүдэлтэй чанарын асуудал үүссэн тул 17 сандлыг байршуулаагүй байсан нь техникийн тодорхойлолтой холбогдон гарсан асуудал тул зөрчлийг тайланд хэвээр үлдээв.
- Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.9-д заасан ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг Сангийн яаманд хүргүүлээгүй байна. Сангийн яам аймгуудаас 4 удаагийн тайланг хүлээн авсан боловч Өвөрхангай аймгаас бүрэн хүргүүлээгүй байна. Иймээс тайлангуудын бүрэн хүргүүлээгүй байсан гэсэн дүгнэлт тусгав.



Тайлан баталгаажуулсан тушаал



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 4/19

Арвайхээр

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 20 дугаар зүйлийн 20.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг”-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан /НАГ-2020/05/-НА/-г баталгаажуулсугай.

2. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн нийцлийн аудитаар өгөгдсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг УАГ-ын Нийцлийн Аудитын Газар, аймгийн ИТХурлын дарга /О.Пүрэвдорж/, аймгийн Засаг дарга /А.Ишдорж/, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга /Г.Баясгалан/, ГХБХБГ-ын дарга /Ч.Гүнсэнхорол/, холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /А.Ишдорж/, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга /Г.Баясгалан/, ГХБХБГ-ын дарга /Ч.Гүнсэнхорол/, холбогдох сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /Д.Гансүх/-т даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР




[Handwritten signature]

Л.ЛАМААЧИН

015010039

D:\Auditin gazar\Baiguullagiiin dotood barimt\Tushaal



Өвөрхангай аймгийн ОНХС-ийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгөгдсөн албан шаардлагын жагсаалт

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөг/	Зөрчлийн утга
1	Аймгийн Засаг дарга	138.3	Аймгийн төвд аймгийн ИТХ-аар батлагдан нийтийн бие засах газар барих 138.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/08 тоот тогтоолоор иргэдийн санал эрэмблэлтэд ороогүй Усан спорт сургалтын төвийн гадна дулаан бохир, гадна цахилгааны ажил болгон өөрчлөн хийсэн байна.
		165.0	Аймгийн төвд аймгийн ИТХ-аар батлагдсан унадаг дугуйн зам барих 165.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг аймгийн ИТХ-ын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03 тоот тогтоолоор иргэдийн санал эрэмблэлтэд ороогүй Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга болгон өөрчилсөн.
		394.9	Аймгийн төвийн Гудамж талбайн камержуулах өргөтгөлийн ажлыг 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Баттод ХХК-тай 394.9 сая төгрөгөөр 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ашиглалтад өгөхөөр гэрээ байгуулан ажилласан боловч одоог хүртэл ашиглалтад оруулаагүй ажил нь дуусаагүй байна.
2	Уянга сумын Засаг дарга	50.0	Сумын ИТХ-ын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий явган хүний зам хийх ажлыг өөрчлөн иргэдийн санал эрэмбэл ороогүй авто замын бордуурын ажил хийж гүйцэтгэсэн байна.
		86.8	Сумын төвд 2020 оны 05 дугаар сард ашиглалтад орсон 86.8 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгт хүрээлэнгийн ажил гаднын нөлөөтэй эвдрэл ихээхэн үүссэн.
		42.0	Сумын төвийн камержуулах 42.0 сая төгрөгийн ажилд хөдөлгөөнт 3, чиглэлийн 3 камер тавигдсан боловч 2 камер гэмтэл үүссэн ашиглалтгүй байна. Камерын ашиглалтын явцад гэмтэл үүссэн талаар захиалагч тал гэмтлийн учир шалтгааныг тодруулаагүй байна.
3	Хужирт сумын Засаг дарга	74.9	1Хужирт суманд дугуйт ковш нийлүүлэх ажлын тендерт Мон Гео Саплай ХХК нь 72.0 сая төгрөгөөр анх үнийн санал ирүүлж тендерийн шаардлага хангаагүй учир хасагдсан байна. Гэвч тус ажлыг тендерийн шаардлага хангаагүй Мон Гео Саплай ХХК-тай 74.9 сая төгрөгөөр буюу анх өгсөн үнийн саналаас 2.9 сая төгрөгийн илүү дүнгээр шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж нийлүүлсэн байна.

		-	Мон Гео Саплай ХХК-ний нийлүүлсэн ковш нь Хятад улсын үйлдвэрийн ковш байсан ба газар дээр очиж үзэхэд техникийн тодорхойлолтоос зөрүүтэй буюу 2019 оноос хойш үйлдвэрлэгдсэн байна гэж заасан боловч тус ковш нь 2017 онд үйлдвэрлэгдсэн байна.
4	Арвайхээр сумын Засаг дарга	5.9	Арвайхээр сумын 3-р багийн төвийн засварын ажил 5.9 сая төгрөгөөр хийгдсэн боловч уг барилгыг нурааж өөр барилга барьж уг хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан.
		39.2	Тус суманд Малчны хороолол бий болгон цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг “Дүүрэн цацрах” ХХК шалгарч 39.2 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад хүлээн авсан боловч одоог хүртэл ашиглалтгүй байна.
		25.0	Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг “Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ 25.0 сая төгрөгөөр 5000 ширхэг хайлаас, 1200 ширхэг улиас тарьж ургуулсан боловч амьдрагч хувь нь 60-аас бага тохиолдолд нөхөн тарилтыг гүйцэтгэгч тал хариуцна гэж гэрээнд тусгасан.
		4.9	Арвайхээр сумын Үерийн далан шуудуу татах, газрын хотгор гүдгэрийг тэгшлэх ажлыг 4.9 сая төгрөгөөр иргэн Д.Буманнаст хийж гүйцэтгэсэн боловч ажлын үр дүн хангалтгүй байна.
5	Гучин-Ус сумын Засаг дарга	44.4	Сумын төвийн айл өрхүүдийн хооронд дулаан болон цэвэр усны шугам тавих ажил 44.4 сая төгрөгөөр хийгдсэн боловч дулааны эх үүсвэргүйн улмаас ашиглаагүй байна.
Нийт дүн		1071.2	